



Үндэсний Статистикийн Хороо




**Нийгмийн халамж
2019 оны 5 сарын байдлаар**

Нийгмийн халамжийн сангийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр, 2002-2018 он



Нийгмийн халамжийн сангийн зарлага, төрлөөр, тэрбум төгрөгөөр, 2010-2018 он



Нийгмийн халамжийн тэтгэвэрт олгосон зардал 2018 онд өмнөх оноос 5.3 хувиар өсч, тэтгэмж, тусламжид зарцуулсан зардал 24.7 хувиар буурч, үйлчилгээ болон хөнгөлөлтөд зориулсан зардал 2.3 хувиар өсжээ.



Нийгмийн халамжийн сан



Нийгмийн халамжийн сангаас 2019 оны эхний 5 сард

- **367.3 мянган хүнд** [өмнөх оны мөн үеэс 2.2 дахин↑]
- **117.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж** [өмнөх оны мөн үеэс 2 дахин↑] олгожээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авсан хүн болон олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ өсөхөд “0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж болон жирэмсэн эхийн тэтгэмж” авсан хүний тоо 3.9 дахин, олгосон тэтгэмжийн хэмжээ 8.2 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Насны хишиг



Жил бүрийн Цагаан сар: Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн

Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярыг тохиолдуулан жил бүрийн 7 дугаар сард



Насны хишиг тэтгэмжийг жилд 2 удаа улсын төсвөөс олгоно.



128.1 (мянган хүн)

10.6 (тэрбум төгрөг)

65-69 настай ахмад настанд

50 000 төгрөг

70-79 настай ахмад настанд

80 000 төгрөг


80-89 настай ахмад настанд

150 000 төгрөг

90, түүнээс дээш настай ахмад настанд

250 000 төгрөг

Нийгмийн халамжийн сангаас алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлсэн тусламж, дүнд эзлэх хувиар, тусламжийн төрлөөр, 2018 он



Нийгмийн халамжийн сангаас 2018 онд алдарт эхийн одонтой 219.4 мянган эхчүүдэд 28.9 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосоны 14.5 тэрбум төгрөгийг нэгдүгээр зэргийн одонтой 74.4 (50.1%) мянган эхчүүдэд, 14.4 тэрбум төгрөгийг хоёрдугаар зэргийн одонтой 145.0 (49.9%) мянган эхчүүдэд олгосон байна.

Алдарт эхийн одонгийн мөнгөн тусламж



Нийгмийн халамжийн сангаас 2019
оны эхний 5 сард

- **210.2** мянган хүнд
- **28.0** тэрбум төгрөгийг алдарт эхийн одонгийн мөнгөн тусламжинд олгожээ.



Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж



Нийгмийн халамжийн сангаас 2019
оны эхний 5 сард

- **221.2** мянган хүнд
- **42.6** тэрбум төгрөгийг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмжинд олгожээ.

Нийгмийн халамжийн тэтгэмж



1. Асаргааны тэтгэмж



53.2 (мянган хүн)
17.7 (тэрбум төгрөг)

2. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж



32.3 (мянган хүн)
10.2 (тэрбум төгрөг)

3. Хүүхдийн мөнгөн тэтгэмж



Энэ оны 5 дугаар сард 18 хүртэлх насны **912.0 мянган** хүүхдэд **91.1 тэрбум** төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмж олгожээ.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2019 оны эхний 5 сард 85.4 мянган хүн хамрагдсаны 62.3 хувь нь асаргааны тэтгэмжид, 37.7 хувь нь онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн тэтгэмжид 2019 оны эхний 5 сард 27.9 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 12.6 (82.9%) тэрбум төгрөгөөр өсжээ.

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН WWW.1212.MN




СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

НӨТРХ | МЭДЛЭГЭЭ ШАЛГАХ | АШИГЛАХ ЗАВААР | ХӨЛӨӨ БАРИХ | EN

СТАТИСТИК | ФАЙЛЫН САН | ГАЗАРҮЙН МЭДЭЭЛЛИЙН САН | ДЭД МЭДЭЭЛЛИЙН САН | ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО | СӨНИРХОЛТОЙ СТАТИСТИК



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын инфографик

эхний 5 сар

ИЛТҮҮ ДЭЛГЭЭРНИЙГ

ХҮН АМ



Энэ бүлэгт Монгол Улсын хүн амын өсөлт, нас хүйсийн бүтэц, төрөлт, нас баралт, гэрлэлт, цуцлалт, үрчлэлт гэх мэт хүн амын ердийн мэд...

ҮНДЭСНИЙ ТООЦОО



Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд тодорхой хугацаанд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, и...

ХӨДӨЛМӨР ӨРХЛЭЛТ, АЖИЛГҮЙДЭГ, ДУНДАЖ ЦАЛИН



Энэ бүлэгт хөдөлмөрийн насны хүн ам, ажиллах хүч, ажиллагчид амьтгүй иргэдийн талаарх мэдээллийг тусгалаа. Зэвсэр үзүүлэлтийг тооцож...

ТЭЭВЭР



Тээврийн салбар нь өргөн уудам нутагтай, хүн ам харьцангуй сийрэг суурьшилтай манай улсын хувьд эдийн засагт чухал ач холбогдолтой са...

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



Статистик



Мэдээ, мэдээлэл



Номын сан



Мэдлэгээ шалгах тоглоом



Валютын ханш



мобайл аппликейшн



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ
СТАТИСТИК

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ
СТАТИСТИК